



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 8/188

Мандалговь

Г Сумдын санхүүгийн албадын зардлыг
зохицуулах тухай Г

Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2017 оны 6 сарын 2-ны өдрөөс Сумдын Засаг даргын Тамгын газрын Санхүүгийн албанд ажиллаж байгаа Боловсролын салбар хариуцсан нягтлан бодогчийг боловсролын салбарын, эрүүл мэнд болон нийтийн ерөнхий үйлчилгээ хариуцсан нягтлан бодогчийг эрүүл мэндийн төвийн төсвөөс тус тус санхүүжүүлсүгэй.

Хоёр. Боловсрол болон эрүүл мэндийн салбараас санхүүжүүлэх шийдвэрийг гарган хэрэгжүүлэхийг Сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Салбаруудын төсөвт зохицуулалт хийн хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга А.Ганбатад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200549